

## Говьд нарны өргүүртэй худаг байгууллаа.



ГИДЦГ-ын “Б” хэсэгт 1992 оноос эхлэн байгаль дээр бүрэн устсан Тахь адууг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах ажлыг хэрэгжүүлж эхлээд 22 жил болж байна. Энэ хугацаанд тахь тээвэрлэх, нутагшуулах ажилд шаардлагатай ихэнхи хөрөнгө, зардлыг Олон улсын төсөл, гадаадын сайн санаат хүмүүсийн хандив, тусламжаар бүрдүүлсээр ирсэн билээ. Тахь нутагшуулах ажилд олон саад бэрхшээл /ган, зуд, өвчин, чоно г.м/ тохиолдож байсан хэдий ч уйгагүй,

нөр их хичээнгүй ажлын үр дүнд Зүүнгарын говьд харьцангуй биеэ даасан Хонь ус /70 гаруй тоо толгой/, Тахь усны /20 гаруй тоо толгой/ гэсэн тахийн 2 популяцийг бий болгож сэргээн нутагшуулах ажлын суурийг баттай бүрдүүлж чадсан юм. Сэргээн нутагшуулсан тахиуд тодорхой байршил нутагт байгалийн жамаараа сүрэглэн, өсөж үржин, улирлын дагуу шилжилт хөдөлгөөн хийж, тоо толгой нь 2010 оноос хойш тогтвортой өссөөр байна.

Хонь усны говь, Тахь ус-Ёлхонд сэргээн нутагшуулсан тахийн 2 популяци хоорондоо байгалийн жамаараа нийлж генетик солилцоо хийгээгүй бөгөөд Тахь усанд 2005 онд сэргээн нутагшуулсан 8 тоо толгой тахь 20 хүртлээ өссөн хэдий ч цус ойртох аюул 2012 оноос эхлэн бодитой нүүрлээд байна. Бид энэ аюулыг бууруулах зорилгоор 2012 онд БНХАУ-ын Жимсайрын Тахь үржүүлгийн төвөөс 4 тахийн азарга Тахь усанд сэргээн нутагшуулсан боловч шинээр ирсэн тахиуд нутагшилтын шатандаа байгаа тул нутгийн азаргатай тулалдаж гүү хураан сүрэг үүсгэтэл нэлээд хугацаа хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой боллоо.

Тахь ус, Хонь усны баян бүрд нь 55 км зайтай/шүүд GPS-ээр заалгахад/, машин замаар 60 км гаруй ба завсрын бэлчээр нутагт байгалийн ямар нэгэн булаг, шанд байдаггүй нь тахийн 2 популяци хоорондоо байгалийн жамаараа нийлэхгүй байгаа үндсэн шалтгаан нь мөн гэдэг нь тодорхой тул шинээр уст цэг гаргах нь тахь нутагшуулах ажлын ирээдүйн амжилтанд бодитой нөлөө үзүүлнэ гэж үзээд Нарны өргүүртэй худгийн санхүүжилтийн хүсэлтийг БОНХЯ-нд 2014.02.10 нд илгээхэд бидний хүсэлтийг маш хурдан дэмжиж 40 сая төгрөгний санхүүжилтийг гаргаж ГИДЦГ-ын “Б” хэсгийн Онгон бүсийн яг голд Хөдөөгийн Сэртэнгийн хойно Улаан ганга гэдэг газар Нарны энергээр ажилдаг худгийг гаргалаа.

Худгийн цооногийг 6м өрөмдөхөд хөрсний ус эхэлж гарсан бөгөөд цааш нь 20м хүртэл өрөмдөж тусгай шүүртэйг трубаг суулгаж ус шахах насосыг 16м гүнд байрлуулсан байна. Усны ундарга маш сайн байгаа бөгөөд 2 л/с орчим ундаргатай байна. Худгийг 2014 оны 3-р сарын 17 хүлээлгэн өгсөн ба 3 сарын 24 гэхэд 7 хоногийн дараа худгийн ус хураах хөвнөөс доош 100м гаруй зайд үерийн усны гангыг дүүргэсэн маш цүнхээ тогтсон байна. Уснаас зээр, хулан ундаалсан байна. 3-р сарын 27 манай байгаль хамгаалагчид “Шинэ ус” хэсээх худгаа эргэхэд худгийн орчимд 1000 гаруй хулан идээшилж байжээ.

Бид худгийн хажууд автомат камер суурилуулсан ба удахгүй утас, унтраалга зэрэг тоног төхөөрөмжийг далдлах, тольны гадуур хамгаалах хашаа бахих, анхааруулах самбар байрлуулах ажлийг хийхээр төлөвлөөд байна. Энэхүү нарны өргүүртэй уст цэг нь ирээдүйд зөвхөн сэргээн нутагшуулсан тахь төдийгүй хулан, хар сүүлт зээрийн усан хангамжыг нэмэгдүүлэхэд бодитой нөлөө үзүүлэнэ гэдэг нь тодорхой байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН “Б” ХЭСГИЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА